# МТҮП-ын 2013 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЛААР ТАНИЛЦУУЛГА

# ХАВСРАЛТ

# Агуулга

**1. Байгууллагын дотоод үйл ажиллагаа** 3
1.1. Хүний нөөцийн чиглэлийн сургалт семинар 3
1.2. Олон нийтийг хамарсан үйл ажиллагаа 3
1.2.1. Цасны баяр 3
1.2.2. “Эко орчин, эрүүл амьдрал” сэдэвт аялал 4
1.2.3. Спорт заалны үйл ажиллагаа 4
1.2.4. Өглөөний цай 4
1.2.5. “Эмнэлэгийн анхны тусламжийн хайрцаг”-ны үйлчилгээ 5
1.3. Гадаад хамтын ажиллагаа 5
1.3.1. World Technopolis Association байгууллагын гишүүн боллоо. 5
1.3.2. БНСУ-ын МТ-ийн сайн дурын ажилчид 6
1.3.3. ASPA –ийн удирдлагуудын уулзалт 7
1.4. Аж ахуйн үйл ажиллагаа 8
1.4.1. Түрээсийн бодлогын шинэчлэл 8
1.4.2. ТӨХ-ны шагнал 9
1.5. Шагнал урамшуулал 9
1.6. “Coworking space” шинэ үйлчилгээ 10
**2. Стратеги, бизнес хөгжлийн төв** 11
2.1. Инкубаторын үйлчилгээ 11
2.1.1. Элсэгчдэд зориулсан семинар 11
2.1.2. Монголын програм хангамжийн анхдугаар чуулган илтгэл хэлэлцүүлэв. 11
2.1.3. Сонгон шалгаруулалтын зөвлөлд гишүүн шалгаруулж авах 11
2.1.4. Сонгон шалгаруулалтын зөвлөлийн гишүүдийг сонгон шалгарууллаа 12
2.1.5. Сонгон шалгаруулалтын маркетингийн үйл ажиллагаа. 12
2.1.6. 20 дахь удаагийн сонгон шалгаруулалт 14
2.1.7. 21 дэх удаагийн сонгон шалгаруулалт 14
2.1.8. “Бизнесийн гарааны цүнх” шинэ үйлчилгээ 15
2.1.9. Инкубаторын 10 жилийн ойд зориулсан арга хэмжээ 16
2.1.10. “МТ-ийн ертөнц” уран зургийн уралдаан 18

2.2. Мэдээллийн технологийн инженерийн шалгалт ... 19
2.2.1. 2013 оны хавар болон намрын МТИШ ... 19
2.2.2. МТИШ-ийн маркетингийн үйл ажиллагаа ... 20
2.2.3. МТИШ-нд сертификат гардууллаа ... 22
2.2.4. МТИШ нь мэргэшсэн инженерийн зэрэг олгох шалгуурт орлоо. ... 23
2.2.5. "Олон улсад оюунаа үнэлүүлэх нь" семинар ... 24
2.2.6. ITPEC- ийн гишүүн орнуудын уулзалт ... 25
2.2.7. Олон улсын асуулт боловсруулагчдын уулзалт ... 25
2.3. Сургалт ... 26
2.3.1. Ухаалаг гар утасны аппликейшн хөгжүүлэгч бэлтгэх сургалт ... 26
2.3.2. Веб хөгжүүлэгч бэлтгэх сургалт ... 26
2.3.3. Компьютерийн хэрэглээний программын сургалт ... 26
**3. Өндөр технологи хөгжлийн төв** ... 27
3.1. Цаг бүртгэлийн тайлан гаргах програм ... 27
3.2. АБЗ-ийн онлайн форумын шинэ үйлчилгээ ... 28
3.3. Инкубаторын платформын шинэ үйлчилгээ ... 29

# 1.Байгууллагын дотоод үйл ажиллагаа

## 1.1. Хүний нөөцийн чиглэлийн сургалт семинар

**Зорилго:** Байгууллагын хүний нөөцийн үйл ажиллагааг тогтворжуулах, мэдлэг ур чадварыг дээшлүүлэх

**Биелэлт: 1.** “Хөшүүргийн хүч”,“Ажлын соёл-Өндөр бүтээмжийн үндэс”, Doc.s, Drop box, “Байгууллагын соёл,харилцааны ёс зүй” сэдэвт сургалтуудыг 5 удаа зохион байгуулж давхардсан тоогоор 124 ажилтан хамрагдлаа.



Зураг 1."Хөшүүргийн хүч" сургалт

## 1.2. Олон нийтийг хамарсан үйл ажиллагаа

### 1.2.1. Цасны баяр

**Зорилго:** Ажилчдын чөлөөт цагийг зөв зохистой өнгөрүүлж,баг хамт олныг бүрдүүлэх. Эрүүл агаарт, эрүүл орчинд аялах

**Биелэлт:**Тэрэлжийн байгалийн үзэсгэлэнт газраар аялан, хамт олны дунд тэмцээн уралдаан зохион байгууллаа.



Зураг 2. Олс таталтын тэмцээн

### 1.2.2. “Эко орчин, эрүүл амьдрал” сэдэвт аялал

**Зорилго:** Байгаль орчноо цэвэр байлгах, эрүүл орчинд аж төрөх, “Эко орчин, эрүүл амьдрал” сэдэвт аялал

**Биелэлт:** 2013 оны 6 сард хамт олноороо Сэлэнгэ аймгийн нутгаар айлчлан байгалын үзэсгэлэнт газруудтай танилцаж, тус аймгийн гүн нуур орчмыг цэвэрлэлээ.



Зураг 3. Сэлэнгэ аймаг

### 1.2.3. Спорт заалны үйл ажиллагаа

**Зорилго:** Ажилчдын эрүүл мэндэд анхаарал тавьж, хөдөлгөөний дутагдлаас хамгаалах, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх.

**Биелэлт:** Долоо хоногт 1 удаа буюу өнгөрсөн жил нийт 48 удаа спорт зааланд очиж нийт давхардсан тоогоор 700 гаруй ажилтан хамрагдлаа.



Зураг 4. Сагсан бөмбөгийн тэмцээн

### 1.2.4. Өглөөний цай

**Зорилго:** Мэдлэг мэдээлэлээ солилцох.

**Биелэлт:** Өглөөний цай арга хэмжээг нийт 5 удаа зохион байгуулсанаар мэдлэг мэдээллээ хуваалцаад зогсохгүй, туршлага солилцдог өглөөний цайтай уулзалт болж чадлаа.



Зураг 5. Өглөөний цай

### 1.2.5. “Эмнэлэгийн анхны тусламжийн хайрцаг”-ны үйлчилгээ

**Зорилго:** Ажилтнуудад эрүүл мэндийн анхны тусламж үзүүлэх

**Биелэлт:** Нийт 26 төрлийн 454 эм, түргэн, анхан шатны тусламжийн эм багтсан.Хүйтэн сэрүүний улиралд ажилчдыг эрүүл байх, өвдсөн тохиолдолд эмнэлгийн анхны тусламж үзүүлэхийн тулд “Эмнэлэгийн анхны тусламжийн хайрцаг”-ны үйлчилгээ нэвтрүүллээ.



**Зураг 6. Анхны тусламжын хайрцаг**

## 1.3. Гадаад хамтын ажиллагаа

### 1.3.1. World Technopolis Association байгууллагын гишүүн боллоо.

**Зорилго:** Шинжлэх ухаан технологийн паркууд, Их дээд сургуулиуд, Судалгаа шинжилгээний хамтран ажиллах, харилцан туршлага солилцох, олон улсын төсөл хөтөлбөрүүдэд хамрагдах.

**Биелэлт:** БНСУ-ын Тэйжион хотод Дэлхийн Технополисын Холбоо, UNESCO-оос хамтран зохион байгуулсан “R&BD 3.0: Бүтээлч эдийн засаг дахь Шинжлэх Ухаан Технологийн Парк” нэрт Олон улсын семинарт оролцон “Дэлхийн Технополисын Холбоо”-нд гишүүнээр элслээ .Дэлхийн 43 орны парк, нийт 91 төвтэй хамтран ажиллах боломж нээгдсэн.




**Зураг 7. Гишүүнчлэлийн сертификат**

## 1.3.2. БНСУ-ын МТ-ийн сайн дурын ажилчид

**Зорилго:** БНСУ-ын Мэдээллийн нийгмийн үндэсний агентлагтай (NIA) хамтран ажиллаж, туршлага судлах, мэдээллийн технологийн сайн дурын багийг өөрийн оронд хүлээн авч ажиллуулах

**Биелэлт:** Энэ удаагийн сайн дурын ажилчдын баг байгууллагын ажилтнууд болон инкубаторын компаниудад солонгос хэлний хичээл заах, хоёр орны соёл, ёс заншилаа танилцуулах, өөрсдийн ажил мэргэжлийн онцлого чиглэлийн дагуу мэдээлэл, туршлага солилцох г.м ажлуудыг хамтран зохион байгуулж ажиллаа.







**Зураг 8. Сайн дурын ажилтнууд**

## 1.3.3. ASPA –ийн удирдлагуудын уулзалт

**Зорилго:** Азийн Шинжлэх Ухаан Технологийн Паркуудын Холбооны 9 дэхудаагийн Удирдлагуудын уулзалтыг амжилттай зохион байгуулах

**Биелэлт:** 2014 оны 6-р сарын 19-21-нд 9 дэхь удаагийн ээлжит Удирдлагуудын уулзалт хурлыг зохион байгуулах эрхийг авсан бөгөөд 1 сард 4 хэл дээр 1000 гаруй хувиар хэвлэгдэгдэж тараагдах улирал тутмын сэтгүүл "ASPA Newsletter"-т тавигдах хурлын талаарх мэдээллийг бэлтгэж байна.



THE 9TH ASPA LEADERS MEETING IN ULAANBAATAR, MONGOLIA

On June 19th through 21, National Information Technology Park (NITP), as the first incubator center in the country, holds the 9th ASPA LEADERS Meeting. This is a kind of capacity building program, which aims to facilitate the exchange of experience and to regularly upgrade the knowledge of leaderships or future managers of science and technology parks on the development of science park and technology business incubator.

This meeting provides various programs so that members of ASPA can exchange information about their experience while enjoying beautiful nature with fresh air as well as nomadic culture in Mongolia. Besides, this is a great opportunity for participants to meet and exchange information with business entrepreneurs from STPs in Asian countries.

This meeting is open to not only the ASPA members but also the entrepreneurs who are related with high-tech industries.

Program

| Pre-day 19th June | | DAY 1 20th June | | DAY 2 21st June | |
|---|---|---|---|---|---|
| | Arrival | 09:00-09:30 | Registration | 09:00-18:00 | Cultural Tour |
| | | 09:30-10:00 | Opening Ceremony | | |
| | | 10:00-10:50 | Keynote Speech | | |
| | | 10:50-11:00 | Break & Networking | | |
| | | 11:00-12:30 | Presentation 1 (Japan) | | |
| | | 12:30-13:30 | Lunch & Networking | | |
| | | 13:40-15:10 | Presentation 2 (Korea) | | |
| | | 15:10-15:30 | Break & Networking | | |
| 15:00-16:30 | ASPA Board of Directors Meeting | 15:30-17:00 | Presentation 3 (Taiwan) | | |
| 17:00-18:00 | Ice Break | | | | |
| 18:00-20:00 | Welcome Reception (informal) | 18:30-22:00 | Farewell Dinner | 18:00 | Departure |

Зураг 9."ASPA Newsletter" -т тавигдах мэдээлэл

## 1.4. Аж ахуйн үйл ажиллагаа

### 1.4.1. Түрээсийн бодлогын шинэчлэл

**Зорилго:** Төрийн эмчийн эд хөрөнгийн түрээсийн үнийг зах зээлийн үнийн жишигт хүргэх

**Биелэлт:** МТҮП-ын ойр орчмын ижил байгууламжуудын түрээсийн үнийн судалгаан дээр үндэслэн УЗ-ын 23-р тогтоолоор м2 -ын доод үнийг 35,000 төгрөг болгон баталсан.



Түрээсийн төлбөр нэмэгдүүлэх,
дамжуулан түрээслэсэн зөрчил арилгах тухай

"Төрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн үнийг зах зээлийн үнэтэй харьцуулан нэмэгдүүлэх тухай" Төрийн өмчийн хорооны 3/2515 тоот албан бичиг, Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгө түрээслүүлэх журам, Удирдах зөвлөлийн 2013 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн хурлын шийдвэрийг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Мэдээллийн технологийн үндэсний паркын түрээсийн 1м2 талбайн доод үнийг 35000/гучин таван мянга/ төгрөг болгохыг Ерөнхий захирал /Ц.Түвшинтөр/-д зөвшөөрсүгэй.
2. Түрээсийн төлбөр шинэчлэгдсэнтэй холбогдуулан түрээслэгч байгууллагуудтай түрээсийн гэрээг шинэчлэн батлахыг Ерөнхий захирал /Ц.Түвшинтөр/-д даалгасугай.
3. 2013 оноос өмнөх Инкубаторт элссэн компаниудад гэрээг дуустал түрээсийн хуучин төлбөрийг мөрдүүлсүгэй.
4. Түрээслэгч байгууллагуудын зөвшөөрөлгүйгээр дамжуулан түрээслэсэн зөрчлийг арилгахыг Ерөнхий захирал /Ц.Түвшинтөр/-д үүрэг болгосугай.

**Зураг 10. Удирдах зөвлөлийн тогтоол**

### 1.4.2. ТӨХ-ны шагнал

**Зорилго:** ТӨХ-д хүлээсэн үүргээ биелүүлэх

**Биелэлт:** Байгууллагын эд хөрөнгийг зохистой ажиллах, төрийн өмчийг эзэмших 49 тоот гэрээг ТӨХ-той байгуулан ажиллаж “ХАНГАЛТТАЙ САЙН” үнэлгээ авч ТӨХ-ний өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнуулав.



Зураг 11. Өргөмжлөл

## 1.5. Шагнал урамшуулал

**Зорилго:** Ажилтнуудаа урамшуулан дэмжих.

**Биелэлт:** Өнгөрсөн онд Алтан гадас одонгоор-1, Салбарын тэргүүний ажилтан-2, Жуух-7, Санхүү банкны тэргүүний ажилтан-1, Залуучуудын холбооны тэргүүний залуу алтан медаль-2, Байгууллагын аврага-1, Газар, төвийн шилдэг-2, хамгийн хамгийн-2 нийт 18 ажилтан шагнал урамшуулал авсан. Мөн шилдэг хэлтсээр Сургалт, зөвлөх үйлчилгээний хэлтэс тодорч хамт олноороо урамгуулал хүртлээ.



Зураг 12. Алтан гадас одон болон жуух авсан ажилтнууд




Зураг 13. Манай шилдгүүд

## 1.6. “Coworking space” шинэ үйлчилгээ

**Зорилго:** Ажил хэрэгч хэн бүхэн ажлын уулзалт, бэсрэг хурал зөвлөгөөн, хэлэлцүүлэг зэрэг бизнесийн олон талт арга хэмжээг зохион байгуулах боломжийг олгох

**Биелэлт:** 2013 оны 11 сараас үйл ажиллагаа явуулж эхэлсэн.


ULS.mn
ИРГЭН ТАНЫ ИНДЭР
Нүүр Улс төр Уул уурхай Эдийн засаг Хууль эрхзүй Нийгэм Гадаад мэдээ Урлаг Ярилцлага

МТҮП-ын “Coworking space”-т Таныг урьж байна

2013-10-28 13:24:42

IT Coworking Space

Coworking space нь Улс орон бүрт өөрсдийн соёлыг илтгэсэн онцлогтой бөгөөд шинэ санаа төрөх, шинээр ажлын байр бий болгох, бусадтайгаа хамтын ажиллагаа өрнүүлэх гарцыг нээж өгдөгөөс гадна хурал зөвлөгөөн, уулзалт ярилцлагаа илүү тав тухтай орчинд, сонирхолтойгоор өрнүүлэх бүтээлч орон зай юм.

Олон улсын томоохон сошиал сүлжээний нэг болох My Space-ийн гүйцэтгэх захирал Майк Жонсоос эхлээд нэр алдартай олон бизнес эрхлэгчид ажлын анхны гараагаа “Coworking space”-ээс эхлүүлж байжээ

Зураг 15. IT Coworking space uls.mn веб хуудаснаа




Зураг 14. Twitter дээр IT Coworking space

# 2. Стратеги, бизнес хөгжлийн төв

## 2.1. Инкубаторын үйлчилгээ

### 2.1.1. Элсэгчдэд зориулсан семинар

**Зорилго:** Элсэхийг хүсэгчдэд инкубаторын журам, бүрдүүлэх материал, шалгуур үзүүлэлт, бизнес төлөвлөгөө боловсруулах аргачлалын талаар мэдээлэл өгөх

**Биелэлт:** 11 сарын 8, 15, 22 –нд 3 удаа өгч давхардсан тоогоор 46 хүн оролцов.



Зураг 16. Семинар

### 2.1.2. Монголын програм хангамжийн анхдугаар чуулган илтгэл хэлэлцүүлэв.




**Зорилго:**Мэдээллийн технологийн програм хангамжийн мэргэжилтнүүд, бүтээгдэхүүн хэрэглэгч, үйлчлүүлэгчдийг нэгтгэн тулгамдаж буй асуудлаа хэлэлцэх.

**Биелэлт:**"Монголын програм хангамж үйлдвэрлэлийн салбарын анхдугаар чуулган" 2013 оны 11-р сарын 11-ны өдөр "Монгол ухаан-Монгол бренд" уриатайгаар зохион байгуулж, Инновацуйн бүтээх ирээдүйн гарааны компаниудыг дэмжих “Seedfund”сэдэвт илтгэл хэлэлцүүллээ.

### 2.1.3. Сонгон шалгаруулалтын зөвлөлд гишүүн шалгаруулж авах

**Зорилго:**Инкубаторын компаниудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийж, үнэлгээ өгөх, сонгон шалгаруулах,үүрэг бүхий орон тооны бус гишүүн шалгаруулалтын зөвлөлд элсүүлэх

**Биелэлт:** Шалгаруулалтын зарыг МТҮП-ын вэб сайт, фэйсбүүк, твиттер хуудас, өдрийн сонин, өнөөдөр сонинд нийтлэн, материал хүлээн авч шалгаруулав.



МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ҮНДЭСНИЙ ПАРК

МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ИНКУБАТОРТ КОМПАНИ, ИРГЭНИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛЖ ЭЛСҮҮЛЭХ, ҮЙЛ АЖИЛЛАГААНД НЬ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ХИЙЖ, ҮНЭЛГЭЭ ӨГӨХ ҮҮРЭГ БҮХИЙ ШАЛГАРУУЛАЛТЫН ЗӨВЛӨЛД ГИШҮҮН СОНГОН ШАЛГАРУУЛЖ АВНА

**Зорилго:**

Мэдээллийн технологийн үндэсний паркийн инкубаторт компани, иргэнийг сонгон шалгаруулж элсүүлэх ажлыг зохион байгуулах, инкубаторын компаниудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийж, үнэлгээ өгөх үүрэг бүхий орон тооны бус шалгаруулалтын зөвлөлд гишүүн элсүүлэх

**Гишүүнд тавигдах ерөнхий шаардлага:**

*Боловсрол:* Санхүү, Эдийн засаг, Маркетинг, Бизнесийн удирдлага, Мэдээллийн технологи болон холбогдох чиглэлээр магистраас доошгүй зэрэгтэй байх.

*Туршлага:* Тухайн мэргэжлээрээ 7 болон түүнээс дээш жил ажилласан, төслийн хяналт үнэлгээний талаар мэдлэг мэдээлэлтэй, төслийн үйл явц, процессын асуудлаар өргөн мэдлэгтэй байх шаардлагатай. Олон Улсын нэр хүнд бүхий Их, Дээд сургууль төгссөн эсвэл Олон Улсын байгууллага, төсөл хөтөлбөр дээр ажиллаж байсан бол давуу тал болно.

**Гол үүрэг:**

- Мэдээллийн технологийн инкубаторт компани, иргэнийг сонгон шалгаруулж элсүүлэх, үйл ажиллагаанд нь хяналт-шинжилгээ хийж, үнэлгээ өгөх
- Төслийн баримт бичигт хяналт-шинжилгээ хийж, үнэлэх

**Материал хүлээн авах:** Тус зөвлөлийн гишүүнээр элсэхийг хүссэн хүмүүс өргөдөл, анкетаа (CV) info@itpark.mn и-мэйл хаягаар ирүүлнэ үү.

**Холбоо барих хаяг:**

Монгол Улс, Улаанбаатар- 14200 Сүхбаатар дүүрэг, Бага тойруу-49

Мэдээллийн технологийн үндэсний парк

Утас: 976-11-318067, 976-11-323357

Факс: 976-11-327121

Зураг 17 .Өдрийн сонинд

### 2.1.4. Сонгон шалгаруулалтын зөвлөлийн гишүүдийг сонгон шалгаруулллаа

**Биелэлт:** Захирлын 170 дугаар тушаалаар сонгон шалгаруулалтын зөвлөлийн гишүүдийг 28 хүний бүрэлдэхүүнтэй баталлаа.



ТӨЛӨВЛӨГӨӨ

МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ИНКУБАТОРЫН ОРОН ТООНЫ БУС ШАЛГАРУУЛАЛТЫН ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

МТШХХГ-ын төлөөлөл - 4

| | | |
|---|---|---|
| 1. | З.Энхболд | МТШХХГ-ын дэд дарга, МТҮП-ын УЗ-ийн дарга |
| 2. | Г.Чинзориг | МТШХХГ-ын Инновацийн хэлтсийн дарга |
| 3. | Б.Буян-Өлзий | МТШХХГ-ын БНҮҮС-гийн Ажлын албаны дарга, МТҮП-ын УЗ-ийн гишүүн |
| 4. | Д.Батбаяр | МТШХХГ-ын Төсөл хөтөлбөрийн хэлтсийн дарга |

МТҮП-ын төлөөлөл - 5

| | | |
|---|---|---|
| 1. | Ц.Түвшинтөр | МТҮП-ын Ерөнхий захирал |
| 2. | П.Наранцэцэг | МТҮП-ын Сургалт, зөвлөх үйлчилгээний хэлтсийн дарга |
| 3. | Д.Чулуунхишиг | МТҮП-ын Инновацийн хэлтсийн Судалгаа, төсөл хөтөлбөр хариуцсан мэргэжилтэн |
| 4. | Ц.Цэцэгмаа | МТҮП-ын Инновацийн хэлтсийн Бизнес хөгжүүлэлтийн мэргэжилэн |
| 5. | Э.Баттулга | МТҮП-ын Инновацийн хэлтсийн Судалгаа, төсөл хөтөлбөр хариуцсан мэргэжилтэн |

Мэдээллийн технологийн чиглэлээр эрдэм шинжилгээ, судалгаа хөгжүүлэлт эрхэлдэг байгууллагын төлөөлөл – 7

| | | |
|---|---|---|
| 1. | Ч.Лодойравсал | МУИС-ийн МТС-ийн захирал, МТҮП-ын УЗ-ийн гишүүн |
| 2. | Ш.Нямбаа | МУИС-ийн МКС-ийн захирал |
| 3. | Б.Сүхбат | ШУТИС-ийн МХТС-ийн захирал |
| 4. | А.Эрдэнэбаатар | ШУТИС-ийн КТМС-ийн профессор багш |
| 5. | Ц.Ганбат | ШУТИС-ийн КТМС-ийн профессор багш |
| 6. | А.Алтангэрэл | ШУТИС-ийн МХТС-ийн профессор багш |
| 7. | Д.Дамдинбаяр | МУИС-ийн Эрдэм шинжилгээ, инновацийн хэлтэс, Технологи дамжуулах төвийн Оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч |

Мэдээллийн технологийн чиглэлийн бизнесийн шинжээч – 6

| | | |
|---|---|---|
| 1. | В.Буянмөнх | MOSA-гийн ерөнхийлөгч |
| 2. | Ц.Буянцогтоо | Юу Эс Ай ХХК-ийн ерөнхий захирал |
| 3. | А.Ууганбаяр | Интерактив ХХК-ийн захирал |
| 4. | Д.Өлзий-Орших | Старсофт ХХК-ийн захирал |
| 5. | С.Ганболд | Нимо Консалтинг ХХК-ийн захирал |
| 6. | Д.Сүхбаатар | Эм Си Эс Холдинг, Мэдээллийн технологийн |

Хөрөнгө оруулагчийн төлөөлөл – 6

| | | |
|---|---|---|
| 1. | Х.Заяажаргал | Зээлийн батлан даалтын сангийн батлан даалтын мэргэжилтэн |
| 2. | Я.Балгансүрэн | Хөдөлмөрийн яамны ЖДҮГ-ын ахлах мэргэжилтэн |
| 3. | Г.Оюунцэцэг | ШУТИС-ийн КТМС-ийн профессор багш |
| 4. | Л.Бямбаа | Мандал Ассет Менежмент ХХК-ийн захирал |
| 5. | Б.Нандин-Эрдэнэ | СЭЗДС-ийн тэнхмийн эрхлэгч |
| 6. | Б.Уламбаяр | Монголын хөрөнгө оруулалт, санхүүгийн зөвлөх компанийн гүйцэтгэх захирал |

Бүгд 28 гишүүн

**Зураг 18. 170-р тушаал**

### 2.1.5. Сонгон шалгаруулалтын маркетингийн үйл ажиллагаа.

**Зорилго:** МТ-ийн инкубаторын тухай түгээчлэн МТ-ийн гарааны компаниудыг дэмжих чиглэлээр мэдээлэл өгөх, сурталчлах

**Биелэлт:** Сонгон шалгаруулалтын маркетингийн хүрээнд элсэлтийн зарыг 9 вэб, инкубаторын э-мэйл лист, сонин,вэб сайтуудад баннер байрлуулах, элсэлтийн шторкыг бэлтгэж телевизүүдээр өдрийн 3 удаагийн давталттайгаар 5 өдрийн турш оргил цагаар цацав.




Зураг 19.  Байгууллагын веб хуудаснаа




Зураг 20.  ШУТИС веб хуудаснаа




Зураг 22. Твиттер хуудаснаа



Зураг 21. Файсбүүк хуудаснаа




Зураг 23. Шторк




Зураг 24 .MGLtimes веб хуудаснаа

### 2.1.6. 20 дахь удаагийн сонгон шалгаруулалт

**Зорилго:** МТ-ийн инкубаторт шинэ санаа, шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ бүхий иргэн, ААН-ийг сонгон шалгаруулах, МТ-ийн салбарт инноваци бүтээх старт-ап компанийг сонгох

**Биелэлт:** 2013 оны 10-р сарын 28-наас 11-р сарын 29-ний өдөр зохион байгуулж 4 иргэн, 11 компани оролцсоноос Алкемист техніложис, SIS ХХК-иуд элсэн орлоо.



Зураг 25. Сонгон шалгаруулалт

### 2.1.7. 21 дэх удаагийн сонгон шалгаруулалт

**Зорилго:** Компьютер вишн, эмбеддэд системийн лаборатори байгуулагдаж буйтай холбогдуулан инкубаторт нэмэлт элсэлт зарлан энэ чиглэлийн компаниудыг дэмжих

**Биелэлт:** Элсэлтээр 2 иргэн 5 компани материалаа өгөв. Сонгон шалгаруулалтыг 1 дүгээр сарын 10-нд зохион байгуулна.




Мэдээллийн Технологийн Үндэсний Паркийн инновацийг бүтээх ирээдүйн гарааны компаниудын энэ оны анхны сонгон шалгаруулалт амжилттай болж өндөрлөлөө. Үүнд нийт 8 компани, иргэн оролцсоноос 5 компани шалгарлаа.

МУ-д эмбеддэд системийн бүтээгдэхүүний хөгжүүлэлтийн гарааны компаниудыг дэмжих нь энэ удаагийн сонгон шалгаруулалтын онцлог байлаа. Иймээс ШУТИС, МУИС зэрэг нэр бүхий сургуулийн эрдэмтэн багш, оюутнуудаас бүрдсэн эмбеддэд системийн бүтээгдэхүүн хөгжүүлэлтийн чиглэлээр ажиллах нийт 5 компани сонгон шалгаруулалтанд тэнцлээ.

Сонгон шалгаруулалтанд оролцсон нийт оролцогчдоо амжилт хүсье. Монгол Улсад эмбеддэд системийн салбар хөгжих болтугай.

Зураг 26. Өнөөдөр сонинд

## 2.1.8. “Бизнесийн гараан цүнх” шинэ үйлчилгээ

**Зорилго:** Мэдээллийн технологийн инкубаторын компаниудын бизнесээ эрхлэхэд шаардлагатай бүх төрлийн үйлчилгээг багцлан олгох бизнесийн гараан цүнх үйлчилгээг нэвтрүүлэх

**Биелэлт:** 2013 оны 12 сард тус үйлчилгээг нэвтрүүлж 2 компани бизнесийн гараан цүнх гардан аваад байна.




Зураг 27. Бизнесийн гараан цүнх




Зураг 28. MGLtimes веб хуудаснаа




Зураг 29 .Amjilt веб хуудаснаа




Зураг 30. Сонинд,Твиттер хуудаснаа




Зураг 31. Өнөөдөр

### 2.1.9. Инкубаторын 10 жилийн ойд зориулсан арга хэмжээ

**Зорилго:** Мэдээллийн технологийн инкубатор үүсэн байгуулагдсаны 10 жилийн ойд зориулсан баярын хурал, програм хангамжийн компаниудын бүтээгдэхүүний үзэсгэлэн, онол практикийн бага хурал зохион байгуулах

**Биелэлт:** 2013.12.19-ний өдөр Corporate convention centre-т зохион байгуулж уг арга хэмжээнд салбарын 102 зочид төлөөлөгчид оролцлоо.




Зураг 32. Баярын хурлыг нээж МТШХХТГ-ын дарга Жадамбаа үг хэллээ.




Зураг 33.Инкубаторын амжилттай төгссөн компаниудын сэтгэгдэл




**Зураг 34.EARP & Cloud Computing талаар илтгэл хэлэлцүүлэг өрнүүллээ.**



**Зураг 35. 10 жилийн ойн хүрээнд зохион байгуулсан үзсэглэнд 14 төгсөгч компани бүтээгдэхүүнээ танилцуууллаа.**

## 2.1.10. “МТ-ийн ертөнц” уран зургийн уралдаан

**Зорилго:** Уран зураг сонирхогч залуусын авъяасыг нээн илрүүлж, уран зургаар дамжуулан мэдээллийн технологийг сурталчлахын зэрэгцээ энэ салбарын ололт амжилт, цаашдын хөгжлийн чиг хандлагыг нь уран сэтгэмжит дүрслэлээр илэрхийлсэн хүсэл мөрөөдлийн мэт өвөрмөц орчинг бүрдүүлэх

**Биелэлт:** Одоогоор 10 уран бүтээлч 11 бүтээлээ ирүүлээд байна.




**Зураг 36. Уран зургийн уралдааны танилцуулга**



**“МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ЕРТӨНЦ, ХӨГЖЛИЙН ИРЭЭДҮЙ” СЭДЭВТ УРАН ЗУРГИЙН УРАЛДААН ЗАРЛАЖ БАЙНА**

Мэдээллийн технологийн хөгжил, ирээдүйн чиг хандлагыг зөгнөсөн сэдвээр (тухайлбал, хиймэл оюун ухаан, I-Robot гэх мэт) монгол хүний амьдралын бүхий л хүрээнд МТ-ийн ололт амжилт хэрхэн тусч байгааг илэрхийлсэн өргөн хүрээг хамарна.

**Уралдааны зорилго:**
Уран зураг сонирхогч хүүхэд залуусын авъяасыг нээн илрүүлж, уран зургаар дамжуулан мэдээллийн технологийг сурталчлахын зэрэгцээ энэ салбарын ололт амжилт, цаашдын хөгжлийн чиг хандлагыг нь уран сэтгэмжит дүрслэлээр илэрхийлсэн хүсэл мөрөөдлийн мэт өвөрмөц орчинг бүрдүүлэхэд уралдааны зорилго оршино.

**Хамрах хүрээ:** Оюутан залуус, зураач, чөлөөт уран бүтээлчид

(босоогоор байрлуулахаар зурах)

**Урсгал чиглэл:** Хэлбэрийн хувьд чөлөөтэй, абстракт, авангард чиглэл, тухайлбал, Science Fiction, Robots чиглэлээр modern, fantasy элементүүд оруулсан байх

**Бүтээлээ ирүүлэх**
Уралдаанд оролцох уран зургуудыг 2014 оны 1-р сарын 2-ноос 7-ны өдрүүдэд ажлын цагаар 209 тоот өрөөнд хүлээж авна.

**Шалгаруулалт**
Шалгаруулалтыг 2014 оны 1-р сарын 8-нд зохион байгуулж, шилдэг 3 бүтээлийг байр эзлүүлэн шагнаж урамшуулна.

**Зураг 37. Өнөөдөр сонинд**

## 2.2. Мэдээллийн технологийн инженерийн шалгалт

### 2.2.1. 2013 оны хавар болон намрын МТИШ

**Зорилго:** МТ болон МТ-ийн бус мэргэжилтэнүүдийн эзэмшвэл зохих мэдлэг, чадварын түвшинг нэгдсэн загварт оруулан тодорхойлж ур чадварын үнэлгээг бий болгох, улмаар тэдний мэдлэг, чадварыг дээшлүүлэх

**Биелэлт:** МТ-ийн олон улсын гэрчилгээ бүхий шалгалтыг удаа 3 түвшний 5 шалгалтыг  зохион байгууллаа. Үүнд нийт: 222 шалгуулагч хамрагдсанаас 24 шалгуулагч тэнцлээ.




**Зураг 38. МТИШ-ын үйл явц**

## 2.2.2. МТИШ-ийн маркетингийн үйл ажиллагаа

**Зорилго:** МТИШ-ыг олон нийтэд таниулах, оролцогчдын тоог нэмэгдүүлэн чанарыг дээшлүүлэх, МТ-ийн мэргэжилтэнүүдийн ур чадварыг олон улсын түвшинд хүргэх

**Биелэлт:** МТИШ-ийн шторкыг шинээр хийж өдрийн 2 удаагийн давталттайгаар Шинэ Дэлхий, TV5, NTV, Eagle, Trade телевизүүдээр цацуулах,**“Олон улсад оюунаа үнэлүүлэх нь**” семинар зохион байгуулах, Шалгалтанд тэнцэгчидтэй хийсэн ярилцлагыг minfo.mn веб хуудсанд байрлуулах, Шалгалттай холбоотой мэдээ мэдээллийг олон нийтийн 5 веб хуудсанд байрлуулах зэрэг ажлуудыг хийв.







Зураг 39. Шалгалтын танилцуулга




Зураг 41.Байгууллагын веб хуудаснаа




Зураг 40.ШУТИС-КТМС-ийн веб







Зураг 43.  УБДС Танилцуулах семинар

Зураг 42. МТИШ-ын тухай,  ШУТИС-ХМТС-ийн вэб хуудаснаа







Зураг 44. МТИШ- дүнг Нийслэлийн МТ-ийн газрын вэб хуудаснаа

Зураг 45. МТИШ- дүнг МОСА-ын вэб хуудаснаа



MMINFO.MN

Entertainment

МУИС-ын МТС-ийн оюутан Ж.Даваахүү: Номыг нэг удаа уншаад өнгөрөх хангалтгүй гэж бодож байна

2013 оны 4 сарын 3

Нэгэн цагт Стив Жобс Стэнфордын их сургуулийн төгсөлтийн баяр дээр хэлсэн үгэндээ "Би хийдэг зүйлдээ үнэхээр дуртай байсан учраас л өдий зэрэгт хүрсэн гэдэгтээ үнэхээр итгэдэг. Та ч гэсэн өөрийн дуртай хийх тэр зүйлийг олох хэрэгтэй" гэж хэлсэн тэр үгийг надад дахин санагдуулах мэргэжилдээ дуртай, ирээдүйдээ итгэлтэй алхах МУИС-ийн МТС-ийн мэдээллийн технологийн инженерийн дөрөвдүгээр курсийн оюутан Ж.Даваахүүтэй ярилцлаа. Тэрбээр суралцах хажуугаар өөрийн мэдлэгээ азийн орнуудын түвшинд үнэлүүлээд авсан нэгэн юм.

**-Азийн орнуудын мэдээллийн технологийн инженерийн шалгалтад тэнцсэн гэж сонслоо. Хаанаас зохион байгуулдаг ямар шалгалт байдаг юм бэ?**

-Тиймээ би өнгөрдөг намар Мэдээллийн технологийн үндэсний паркаас Азийн орнуудын мэдээллийн технологийн мэргэжилтнүүдийн шалгалтын Зөвлөл/ ITPEC/-тэй хамтран зохион байгуулдаг "Мэдээллийн технологийн инженерийн шалгалт"-ыг өгч тэнцээд Азийн 12 оронд хүлээн зөвшөөрөгддөг сертификатыг гардан авсан юм. Энэ шалгалт жил бүр хавар, намар зохион байгуулагддаг учраас манай салбарынхан энэ шалгалтын талаар нэлээд сайн мэддэг. Учир нь энэ шалгалт бидний мэдлэгийг үнэлэх гол хэрэгслээс гадна азийн бусад оронд мэргэжлээрээ ажиллах боломжийг олгодог

Зураг 46.МТИШ-нд тэнцэгчийн сэтгэдэл www.mninfo.mn веб хуудаснаа




Зураг 47. МТИШ-ийн танилцуулга/шторк/

## 2.2.3. МТИШ-нд сертификат гардууллаа

**Зорилго:** МТИШ-ийн шалгалтанд тэнцсэн тэнцэгчдэд Азийн 7 оронд хүлээн зөвшөөрөгдсөн батламж гардуулах

**Биелэлт:** 2013 оны 7 дугаар сарын 3-ны өдөр МТИШ-нд тэнцэгч Б.Батзангиа, Р.Мөнхчимэг, Б.Ганхөлөг, Б.Галдансүрэн нар МТҮП-ын Стратеги, Бизнес хөгжлийн төвийн дарга Ш.Эрдэнэчимэг, Сургалт, Зөвлөх үйлчилгээний хэлтсийн дарга П.Наранцэцэг нараас сертификатаа гардан авлаа.



МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ҮНДЭСНИЙ ПАРК

ЭХЛЭЛ ТАНИЛЦУУЛГА

4 Jul 2013

МТИШ-нд тэнцэгч Б.Батзангиа, Б.Ганхөлөг, Б.Галдансүрэн, Р.Мөнхчимэг нар сертификатаа гардан авлаа.

LEAVE A COMMENT

2013 оны 7 дугаар сарын 3-ны өдөр МТИШ-нд тэнцэгч Б.Батзангиа, Р.Мөнхчимэг, Б.Ганхөлөг, Б.Галдансүрэн нар МТҮП-ын Стратеги, Бизнес хөгжлийн төвийн дарга Ш.Эрдэнэчимэг, Сургалт, Зөвлөх үйлчилгээний хэлтсийн дарга П.Наранцэцэг нараас сертификатаа гардан авлаа.

Эдгээр тэнцэгчдээс МТПШ-нд тэнцэгч Мөнхчимэг нь барилгын нэгэн компанид инженер хийдэг бөгөөд МТ-ийн мэргэжилийн бус хүн байсан Мөнхчимэгийн хувьд маш том амжилт юм.

Харин МТИСШ-нд тэнцсэн Б.Батзангиа Интерактив ХХК-нд ажилладаг бөгөөд хаврын шалгалтанд хамгийн өндөр оноог авсан юм.

Зураг 48.МТИШ-нд тэнцэгчид байгууллагын веб хуудаснаа

## 2.2.4. МТИШ нь мэргэшсэн инженерийн зэрэг олгох шалгуурт орлоо.

**Зорилго:** Зөвлөх мэргэшсэн инженерийн зэрэг олгох шалгуурт МТИШ-нд тэнцсэн байх гэсэн заалт нэмэлтээр оруулах

**Биелэлт:** 2013 онд Мэдээлэл холбоо технологийн сургууль /МХТС/ болон МТШХХГ-ын (дарга Ц.Жадамбаа) санаачлагаар салбарын инженерүүдэд мэргэшлийн зэрэг олгох зөвлөлийг шинэчлэн зохион байгуулж, сургалт, шалгаруулалтын үйл ажиллагаа болон холбогдох дүрэм журамд цогц өөрчлөлтийг оруулж Зөвлөлийн хурлаар шинэчлэн батлахад хамтран ажиллав.



Дүрэм, журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, "Мэдээлэл, холбооны технологийн салбарын мэргэжилтэнд мэргэшлийн зэрэг олгох зөвлөл"-ийн 2013 оны 9 дүгээр сарын 18-ны өдрийн 2 дугаар хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

Нэг. "Мэдээлэл, холбооны технологийн салбарын мэргэжилтэнд мэргэшлийн зэрэг олгох зөвлөлийн дүрэм"-ийг нэгдүгээр, "Мэдээлэл, холбооны технологийн салбарын мэргэжилтэнд мэргэшлийн зэрэг олгох журам"-ыг хоёрдугаар, "Шалгалт авах журам"-ыг гуравдугаар хавсралтаар тус тус батлсугай.

Хоёр. Дээрх дүрэм, журмын хэрэгжилтийг хангуулан, хяналт тавьж ажиллахыг зөвлөлийн орлогч дарга, шалгалтын комиссын дарга /Б.Сүхбат/-д даалгасугай.

**Зураг 49. МТШХХГ-ын даргын 243-р тушаал**

## 2.2.5. “Олон улсад оюунаа үнэлүүлэх нь” семинар

**Зорилго:** МТИШ-ыг сурталчлах, шалгалтын ач холбогдлыг МТ-ийн болон бусад салбарын мэргэжилтнүүдэд таниулах, хөдөө орон нутгийн мэргэжилтнүүдийг хамруулах боломжийг судлах, хамруулах

**Биелэлт:** Улаанбаатарт, Дархан хотуудад зохион байгуулж, нийт 135 оролцогчыг хамруулаа.



Зураг 51. Улаанбаатар хот



Зураг 50. Дархан-Уул аймаг ЗДТГ-ийн байр




Зураг 52. Семинарын танилцуулга




Зураг 53. Семинарын урилга

### 2.2.6. ITPEC- ийн гишүүн орнуудын уулзалт

**Зорилго:** ITPEC-ийн гишүүн улс орнууд МТИШ-ын дүнг тайлагнах

**Биелэлт:** 2013 оны 9 сарын 5, 6-ны өдрүүдэд Мянмарын нийслэл Янгон хотноо зохион байгуулагдсан бөгөөд МТҮП-ын захирал Ц.Түвшинтөр оролцож шалгалтын системийг сайжруулах талаар танилцуулав



Зураг 54.Захирлуудын уулзалтанд оролцогчид

### 2.2.7. Олон улсын асуулт боловсруулагчдын уулзалт

**Зорилго:** МТИШ-ын асуултуудыг сонгон шалгаруулах

**Биелэлт:** МТИШ-ын Олон улсын асуулт боловсруулагчдын уулзалт Тайланд улсын Бангкок хотноо 2013 оны 11-р сарын 27-оос 11-р сарын 29-нийг дуустал амжилттай зохион байгуулагдав. Уулзалтанд нийт 8 орны 23 төлөөлөгч оролцсон бөгөөд Монгол улсаас МУИС-ийн МТС-ийн "Электроникийн тэнхим"-ийн эрхлэгч д.р Д.Болормаа, ШУТИС-ийн КТМС-ийн "Мэдээллийн системийн профессорын баг"-ийн багш Д.Золбоо, МТҮП-ын МТ-ийн ур чадвар, стандарт хариуцсан мэргэжилтэн Ч.Сувд нар оролцлоо.




Зураг 55.Олон улсын асуулт боловсруулагчдын уулзалтанд оролцогчид

## 2.3. Сургалт

### 2.3.1. Ухаалаг гар утасны аппликейшн хөгжүүлэгч бэлтгэх сургалт

**Зорилго:** Мэдээлийн технологийн салбарын хүний нөөцийг чадавхжуулах, мэдлэг ур чадварыг дээшлүүлэх зорилгоор онол, практик сургалтыг хослон явуулах

**Биелэлт:** Сургалтыг 2 удаа зохион байгуулж нийт 53 хөгжүүлэгчдийг бэлтгэн гаргав.




**Зураг 56. Үнэгүй, зармэдээ, фэйсбүүк зэрэг веб хуудсуудад**

### 2.3.2. Веб хөгжүүлэгч бэлтгэх сургалт

**Зорилго:** Олон улсан мэргэжлийн програм хангамжийн инженерүүдийн ашиглаж буй шинэ дэвшилтэт техник технологи, програм хангамжуудыг ашиглаж сурах хийж буй бүтээлийг чанартай болгох.

**Биелэлт:** Веб хөгжүүлэлтийн сургалтыг21 хоног зохион байгуулж, нийт 20 хүнийг бэлтгэн гаргав.




**Зураг 57. Веб хөгжүүлэгч бэлтгэх сургалт файсбүүк хуудаснаа**

### 2.3.3. Компьютерийн хэрэглээний программын сургалт

**Зорилго:** Төрийн болон төрийн бус байгууллагуудын албан хаагч, мэргэжилтэн нарт компьютерийн хэрэглээний анхан, дунд, гүнзгий шатны мэдлэг олгох

**Биелэлт:** Сургалтыг 5,11 сард зохион байгуулж нийт 100 мэргэжилтэнг бэлтгэн гаргав.



**Зураг 58. Компьютерийн хэрэглээний программын сургалт файсбүүк хуудаснаа**

# 3. Өндөр технологи хөгжлийн төв

## 3.1. Цаг бүртгэлийн тайлан гаргах програм

**Зорилго:** Ажилчдын цаг ашиглалтыг хянах, хоцрогдлыг арилгах.

**Биелэлт:** Цагийн бүртгэлийн програм нь хуруу уншиж ирц бүртгэх төхөөрөмж рүү хандан ирцийн мэдээллийг авч ажилчин бүрийн сард хэдэн минут хоцорсон хэдэн цаг ажилласаныг харуулсан тайланг үүсгэнэ. Мөн тайланг ажилчны и-мейл хаягаар автоматаар явуулна.

- Хэлтэс бүртгэх, засварлах, устгах боломжтой
- Ажилчин бүртгэх,засварлах, устгах боломжтой
- Төхөөрөмж рүү хандаж бүртгэлийн лог файл унших
- Ажилчдын ирцийн тайлан гаргах
- Ажилчдын ирцийн тайланг и-мейл рүү нь явуулах



Зураг 59.Цаг бүртгэлийн тайлан гаргах програм



Зураг 60.Цаг бүртгэлийн тайлан гаргах програм-Хэлтэс удирдас цонх



Зураг 61.Цаг бүртгэлийн тайлан гаргах програм - Ажилчин удирдах цонх



Зураг 62.Цаг бүртгэлийн тайлан гаргах програм - Тайлан гаргах цонх

# 3.2. АБЗ-ийн онлайн форумын шинэ үйлчилгээ

**Зорилго:** МТИШ-ын зөвлөлийн **асуулт боловсруулах** хэлэлцүүлэх үйл ажиллагааг онлайнд шилжүүлэх

**Биелэлт:** Хэрэглэгч системд бүртгүүлээд өөрийн асуултаа оруулах боломжтой ба хэрэглэгч өөрийн болон бусад хэрэглэгчдийн асуултыг LIKE, DISLIKE дарч асуултанд саналаа өгөх боломжтой.



Зураг 64. АБЗ системийн нүүр хуудас



Зураг 63. АБЗ системийн асуулт харуулах хуудас



Зураг 66. Системийн асуулт хэлэлцэх хуудас



Зураг 65. АБЗ системийн асуулт бүртгүүлэх цонх

## 3.3. Инкубаторын платформын шинэ үйлчилгээ

**Зорилго:** Инкубаторын компанийг бүртгэх, компаниудын тайлан тооцоог авах дүгнэх, зар мэдээлэл тараах, хэрэгтэй бичиг баримт, файлаар хангах зэрэг инкубаторын дотоод үйл ажиллагааг онлайн хэлбэрт шилжүүлэхээс гадна ажил санал болгох иргэн компанийг ажил гүйцэтгэх мэдээллийг технологийн компаниудтай холбож өгөх

**Биелэлт:**

- Инкубаторын менежер компани бүртгэж авна.
- Сарын тайланг онлайнаар хүлээн авч үнэлнэ.
- Хагас жилийн тайланг онлайнаар хүлээн авч үнэлнэ.
- Зар мэдээлэл инкубаторын компаниудад хүргэнэ.
- Компаниудад хэрэг болом бичиг баримт, мэдээллээр хангана
- Компани сарын, хагас жилийн тайлангаа явуулна.
- Ажлын санал бүртгэн авч компаниудад хүргэнэ.



Зураг 69.Инкубаторын платформын компани бүртгэх хуудас



Зураг 67.Инкубаторын платформын зар мэдээллэл хүргэх хуудас



Зураг 68.Инкубаторын платформ- Сарын тайлан хүлээн авах хуудас



Зураг 70. Инкубаторын платформ - Компаний удирдлагын хуудас



Зураг 71. Инкубаторын платформ - Ажлын санал харуулах хуудас